



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 142

Улаанбаатар хот

Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж
үйлчилгээний талаар авах зарим
арга хэмжээний тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.4, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйл, Эрүүл мэндийн салбарын суурь шинэчлэлийн бодлогын тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн хяналтад байдаг Улаанбаатар хотын харьяат оюуны хүнд хэлбэрийн хомсдолтой үйлчлүүлэгчдийг харьяа дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн хяналтад шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал (Л.Насанцэнгэл), Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга (С.Туул) нарт үүрэг болгосугай.

2. Дүүргийн мэргэжилтнүүдийг оюуны хомсдолтой үйлчлүүлэгчдэд тусламж үйлчилгээ үзүүлэх, хянах талаарх сургалтад хамруулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал (Л.Насанцэнгэл)-д үүрэг болгосугай.

3. Сэтгэцийн болон наркологийн эмч, мэргэжилтнүүдийн судалгаа гаргаж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 6330-4:2012, нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны MNS 5095:2013 стандартаар ажиллахад шаардлагатай сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудыг сургалтад хамруулах ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал (Ч.Бат-Эрдэнэ), Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий захирал (Л.Насанцэнгэл) нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал), Хяналт - шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.

САЙД  Н.УДВАЛ